

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл (цаашид “Зохицуулах зөвлөл” гэх)-ийг байгуулах, түүний гишүүдийг томилж, чөлөөлөх, тэдгээрийн эрх, үүрэг санхүүгийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зохицуулах зөвлөл нь чиг үүргээ бие даан, хараат бусаар хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актууд, энэхүү журам болон “Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн дүрэм”-ийг баримтална.

Хоёр. Зохицуулах зөвлөлийг байгуулах, түүний үйл ажиллагаа, чиг үүрэг

2.1. Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасны дагуу Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг байгуулж, Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн дүрмийг батална. Зохицуулах зөвлөл нь улсын бүртгэлд бүртгэгдсэнээр үйл ажиллагаа явуулах эрх үүснэ.

2.2. Зохицуулах зөвлөл нь Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж ажиллах бөгөөд холбогдох хууль тогтоомж болон Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан дүрэм журмуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана

2.3. Зохицуулах зөвлөл нь шийдвэрлэх асуудлаа Зөвлөлийн хурлаар хэлэлцэнэ. Хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Хурлын явцад дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө. Тогтоолыг тухайн зөвлөлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний үйлчлэх хүрээнд хамаарах хэрэглэгчид дагаж мөрдөнө.

2.4. Зохицуулах зөвлөл нь үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал, хагас жил, жил тутамд Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлж байх бөгөөд Эрчим хүчний зохицуулах хороо нь жил бүр, шаардлагатай бол тодорхой хугацаанд үнэлэлт, дүгнэлт өгнө.

Гурав. Зохицуулах зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх

3.1. Зохицуулах зөвлөлийн гишүүдийг тухайн Аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн Эрчим хүчний зохицуулах хороо томилж, чөлөөлнө.

3.2. Зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүдийн нэг нь тухайн аймгийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч, нөгөө нь дараах албан хаагчдаас нэгийг нь сонгож томилно.

3.2.1 Тухайн аймгийн дэд бүтцийн асуудал хариуцсан Засаг даргын орлогч (Хотын статустай бол хотын захирагчийн орлогч, менежер)

3.2.2 Тухайн аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгжийн дэд бүтэц, эрчим хүчний асуудал хариуцсан мэргэжилтэн

3.3. Зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүд үндсэн албан тушаалаасаа өөрчлөгдсөн тохиолдолд шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор Эрчим хүчний зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Хорооны хурлаар хэлэлцүүлж, Зохицуулах зөвлөлийн гишүүнээс чөлөөлнө.

3.4. Зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн нь эрчим хүчний инженер, инженер, эрхзүйч, нягтлан бодогч, эдийн засгийн мэргэжилтэй, тухайн мэргэжлээрээ гурваас дээш жил ажилласан иргэн байна. Орон тооны гишүүнийг ажилд авахдаа шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулж болно. Энэ тохиолдолд ЭХЗХ-ны Хөдөлмөрийн дотоод журамд заасан холбогдох заалтуудыг баримтална.

3.5 Зохицуулах зөвлөлийн даргаар энэхүү журмын 3.2.1-д заасан орон тооны бус гишүүнийг эсхүл орон тооны гишүүнийг томилж болно.

3.5.1 Орон тооны гишүүнийг зохицуулах зөвлөлийн даргаар томилох тохиолдолд орон тооны гишүүн нь эрчим хүчний салбарт 5-с доошгүй жил ажилласан, төрийн байгууллагад ажилласан туршлагатай Монгол улсын иргэн байна.

3.6 Эрчим хүчний зохицуулах хороо нь Зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүнийг ажлаас чөлөөлөхдөө Хөдөлмөрийн тухай хууль, тухайн ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, Хорооны хөдөлмөрийн дотоод журам, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Зохицуулах зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэн эрх

4.1. Зохицуулах зөвлөлийн дарга нь дараах эрх, үүрэгтэй:

4.1.1 Зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хурлыг товлож, даргалах;

4.1.2 Зохицуулах зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, гүйцэтгэлд хяналт тавих;

4.1.3 Эрчим хүчний зохицуулах хороогоор хянуулсан зохицуулах зөвлөлийн зардлын төсвийг зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах, захиран зарцуулах;

4.1.4. Зохицуулах зөвлөлийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулах, ажлын үр дүнг харгалзан шагнаж урамшуулах, гадаад, дотоодын сургалтад хамруулах, бусад дэмжлэг үзүүлэх;

4.1.5. Хууль тогтоомж болон энэ дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

4.2. Зохицуулах зөвлөлийн орон тооны бус гишүүн дараах эрх, үүрэгтэй:

4.2.1 Зохицуулах зөвлөлийн хуралд биечлэн болон цахимаар оролцох, санал өгөх;

4.2.2 Зохицуулах зөвлөлийн эрх, үүрэгт хамаарах асуудлаар санал дэвшүүлж, хэлэлцүүлэх;

4.2.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хуульд заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.2.4 Зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүний 1 сар хүртэл хугацаагаар эзгүй үед (өвчтэй, чөлөөтэй бусад хүндэтгэн үзэх шалтгаантай) эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн эрхтэй орон тооны бус гишүүн орлон эсхүл хавсран ажиллах;

4.3. Зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн нь дараах эрх, үүрэгтэй:

4.3.1 Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Зөвлөлийн гишүүд болон Эрчим хүчний зохицуулах хороог холбогдох мэдээллээр хангах

4.3.2. Зохицуулах зөвлөлийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийг баталгаажуулж, холбогдох этгээдэд хүргүүлэх;

4.3.3 Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны хагас жил, жилийн тайлан, төлөвлөгөөний гүйцэтгэл, зардлын төсвийн саналыг орон тооны гишүүний ажлын байрны тодорхойлолтод заасан хугацаанд Эрчим хүчний зохицуулах хороонд ирүүлэх

4.3.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү, эдийн засгийн байдал, үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний саналыг Зохицуулах зөвлөлийн гишүүд болон Эрчим хүчний зохицуулах хороонд тайлагнах;

4.3.5. Зохицуулах зөвлөлийн даргын эзгүйд олон нийтэд чиглэсэн шийдвэр гаргахаас бусад тохиолдолд орлоно;

4.3.6. Эрчим хүчний зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой асуудлаар Хороог мэдээллээр хангах, хамтран ажиллах;

4.3.7 Эрчим хүчний зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулсан хэрэглэгчээс Зохицуулах зөвлөлд өргөдөл, гомдол гаргасан тохиолдолд Хороонд шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд газар дээр нь ажиллаж Хороог мэдээллээр хангах;

4.3.8 Орон тооны гишүүн нь зохицуулах зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцоно.

4.3.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хуульд заасан эрх, үүргийн хүрээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

Тав. Зохицуулах зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаа

5.1 . Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын үйлчилгээний хөлсөөр өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.

5.2. Эрчим хүчний зохицуулах хорооны баталсан “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ын дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцно.

5.3. Засгийн газрын 2016 оны 132 дугаар тогтоолоор баталсан "Эрчим хүчний зохицуулах хорооны дүрэм"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.5 дахь заалтуудыг үндэслэн Аймаг, Нийслэлийн зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсөв, төсвийн гүйцэтгэл, гишүүдэд олгох цалин, урамшуулалтай холбоотой харилцааг "Аймаг, Нийслэлийн зохицуулах зөвлөлийн дүрэм"-ээр зохицуулна.

Зургаа. Хяналт, хариуцлага

6.1 Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийг байгуулах, томилох, чөлөөлөх журмын биелэлтэд Эрчим хүчний зохицуулах хороо хяналт тавина.

6.2 Энэхүү журам зөрчсөн этгээдэд Эрчим хүчний тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ.